

Түрэн гарч ирж буй Азийн бүсчлэл

Хамтран хөгжихийн төлөө түншлэлийн холбоо

Азийн улсуудийн эдийн засаг өөр хоорондоо болон дэлхийд чухал нөлөө үзүүлдэг болсоор байна. Хөгжиж буй Азийн улсуудад учирсан сорилтуудыг даван туулахын тулд дэлхийн эдийн засгийн түншлэл болон удирдлагатай бат бөх бүтээлч үүрэг гүйцэтгэхийн ялдамд бүсийн хамтын ажиллагааны ашиг тусыг бэхжүүлэн түүний цар хүрээг өргөтгөх зорилт тулгарч байна. Азийн эдийн засгууд өсөн томорч улам цогц болох тусам нэгдэцгээж байна.

Зах зээлийн эдийн засагтай орнуудын засгийн газар зах зээлийн хуулийг дагах хэрэгтэй болдог. Дэлхий дахины бодлогын бүтцийн нэг хэсэг болсон Азийн бүсийн эдийн засгуудын нэгдэл болон уг бүсийн нэгдсэн ашиг сонирхол, түүнчлэн хожим ил болсон болсон сул талуудыг 1997/98 оны хямрал онцлон харуулсан. Энэ хямрал Азийн бүсчлэл бий болоход түлхэц өгч засгийн газар хоорондын хамтын ажиллагааны шинэ санаачлагууд руу хөтөлсөн. Харин Азийн албан ёсны хамтын ажиллагааг хариуцах албан ёсны байгууллагууд нь дөнгөж эхлэлийн төдий байгаа ба түүгээр ч барахгүй шинэ байгууллагуудыг шинээр бий болгох шаардлага гарч ирж байна. Бүсийг бараа таваараар хангах, улс хоорондын арилжааны илүүдлийг арилгах, дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтуудад Азийн нөлөөг мэдрүүлэх, арилжаа болон хөрөнгө оруулалтыг чөлөөтэй явуулах, Азийн бүс нутгийн чухал ашиг сонирхол орсон үндэсний бодлогуудыг сайжруулах зэрэг сорилтууд тулгарч байна.

Бүсийн хамтын ажиллагааг улс орнууд хувийн ашиг сонирхолдоо ашиглах биш хоорондын харилцаа холбоо зохицуулах хэрэгсэл болгож мөрдөх ёстой. Хурдацтай хөгжиж буй олон талт Азийн бүсчлэл нь дэлхийн эдийн засгийг хүчирхэгжүүлж тогтворжуулахад хувь нэмэрээ оруулах болно. Бүсүүд хамтын ажиллагаагаараа дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн дэвшилд хувь нэмэрээ оруулж буйн нэг жишээ бол Азийн хамтын ажиллагаа юм.

Үйлдвэрлэлтийг Нэгтгэх

Азийн худалдаа болон санхүү, хөрөнгө оруулалтын хоорондын холбоонд ахиц гарч байгаа бөгөөд бүсийн үйлдвэрлэлтийг нэгтгэснээр дэлхийн үйлдвэрлэлд Азийн бүс нутаг удирдах төв нь болж чаджээ. Энэ бүсэд бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн процесс нь хуваагдсан бөгөөд үйлдвэрлэлтийн шат дамжлага бүрт хамгийн бага өртгөөр үйлдвэрлэж чадаж байна. Азийн орнуудын үйлдвэрлэлийн энэхүү хоорондын холбоотой байдал нь Азийн улсуудыг гадаадын хөрөнгө оруулалт худалдааг татах гол давуу тал болж байна. Бүсийн хамтын үйл ажиллагаанд учрах сорилтуудад Азийн үйлдвэрлэлийн сүлжээг нэгтгэх ажлыг дэмжих бас арилжаа хөрөнгө оруулалтын нээлттэй хууль дүрэмд захирагдсан гадаадын системд зохицож ажиллах чадварыг олж авах зэрэг орно. Дэлхийн худалдааны тогтолцоог хөгжүүлэхийн тулд Азийн бүс өөрийн нөлөөллийг ашиглах хэрэгтэй. Дэлхийн шилдэг дадлага туршлагуудыг ажил хэрэг болгосноор амжилт олж болохын чацуу тэдгээрийн тусламжтайгаар бүсийн болон дэд бүсийн хоорондын чөлөөт худалдааны гэрээнүүдийг байгуулж болох юм. Бүс нутгийн улсуудын эдийн засгийг холбоход улс хоорондыг дамнасан дэд бүтцэд гадаадын хөрөнгө оруулалт хийх шаардлага гарна.

Санхүүгийн зах зээлийг нэгтгэх

Азийн бүсийн орнуудын санхүүгийн нэгдэл нь худалдааны нэгдлийн түвшинд хүрэхгүй. Энэхүү санхүүгийн нэгдэл нь Азийн том том хадгаламжууд болон хөрөнгө оруулалтын боломжуудыг эс тооцон дэлхийн санхүүгийн зах зээлээр зуучлуулан явагддаг. Санхүүгийн нэгдлийг лавшруулах нь санхүүгийн тогтолцоо, түүний дотор эдгээртэй холбоотой хуулийн бүтцийг улам боловсронгуй болгохоос хамаарна. Эдгээр боловсронгуй аргууд яваандаа ашиг тусаа өгөх мөчлөгүүд рүү хөтөлнө. Үүнд: Бүсийн зах зээлд нэмэлт хөрөнгө (Азийн хөрөнгө оруулалт хамаарна) оруулснаар шинэ бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэгдэж үр ашигтай, анхаарал татахуйц зах зээл аяндаа бий болно. Санхүүгийн зах зээлийн удирдлага, хяналтыг чангатгах, мөн санхүүгийн зах зээл дэх тохиролцоо хэлэлцээг аль болох чухалчлах хэрэгтэй. Шинэ, өндөр зэрэглэлийн байгууллага -"Азийн Санхүүг Тэнцвэржүүлэх Харилцан Яриаг" бий болгож, бүсийн эрх баригчид санхүүгийн зах зээл дэх хүндрэлтэй асуудлууд болон хуулиудыг авч хэлэлцэж, мөн хувийн хэвшилтэй санал солилцож, санхүүгийн яамд, төв банк, хянагчид болон хууль тогтоогч нарыг нэгтгж зангидах болно. Түүнчлэн орнуудад

харилцан хүлээн зөвшөөрөлцөх нөхцөл бүрдүүлэхийн тулд жишигт тогтсон журмыг сонгон авах, санхүүгийн хуулиудыг уялдуулан зохицуулах зэргийг юуны түрүүнд авч хэлэлцэх шаардлагатай. “Азийн Үнэт Цаасны Зах Зээлийн Санаачилга” болон “Азийн Үнэт Цаасны Фонд” зэрэг байгууллагуудыг өсгөж өргөжүүлэхээс гадна энэ бүс нутагт төлбөр тооцоо хийх, төлбөрийн зохицуулалт хийх, мөн санхүүгийн мэдээлэл солилцооны бат бөх системийг байгуулах хэрэгтэй. Хөрөнгийн данс болон улс хоорондын санхүүгийн үйл ажиллагааны урсгалыг нарийн тооцож чөлөөлвөл дотоодын санхүүгийн тогтолцоо үр бүтээмжтэй болох болно.

Макро эдийн засгуудын хоорондын уялдаа холбоог зохицуулах

Азид худалдаа болон хөрөнгө оруулалтын хоорондын зангилаа нэмэгдэх тусам Азийн макро эдийн засгуудын хоорондын уялдаа холбоо нэмэгдэж байна. Гэхдээ Азийн орнууд макро эдийн засгийн бодлогын түвшинд хамтран ажиллах нь бага байгаа нь ажиглагддаг. Хяналтын механизмыг бэхжүүлснээрээ макро эдийн засаг болон валют солилцооны ханшны бодлогын зохицуулалтаас ашиг олж болохоор байна. “Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо +3” - ны эдийн засгийг дүгнэх болон бодлого тодорхойлох харилцан хэлэлцээг цаашид улам хүчтэй болгох хэрэгтэй байгаа ч, Азийн улс төрийн эрх баригчид “Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Нарийн Бичгийн Дарга Нарын Газар” гэж байгуулан түүгээр гадаадын валютын нөөцийг хянуулж, хямралын үед дэмжлэг эрэлхийлж байгаа засгийн газруудад эдийн засгийн бодлогын талаар зөвөлгөө өгч, яриа хэлэлцээ хийж байх боломж байгааг авч үзэх хэрэгтэй. Хямралын үед “Чианг Май Санаачлага”-ын дагуу олон талт хэлэлцээ хийх, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах даралт шахалтыг хөнгөрүүлэх зэргээр ажиллах боломжтой. Түүнчлэн бүс нутаг даяар мөнгөний болон валютын ханшны бодлогыг оновчтой болгох давуу тал байгаа юм.

Хөгжилийг ахиулж тогтвортой болгох

Азийн ихэнх улсуудын ядуурлыг амжилттайгаар даван туулж багасгаж байгаа ч бараг бүгдээрээ өсөж дэвшиж чадахгүй байгаа том хүндрэлтэй тулгарч байна. Улс орнуудын үндэсний бодлого нь нийгмийн асуудлуудыг шийдэхэд чиглэгддэг боловч тухайн орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг багасгах бодлогуудаа бүс нутгийн хэмжээнд яаж шийдвэрлэх вэ гэсэн сорилт тулгардаг. Ажиллах хүчний зах зээл дэх бартаа бэрхшээлийг арилгаж, ажилчдыг мэргэшүүлэхэд хөрөнгө оруулж, мөн дэд бүтцийг хөгжүүлснээр төр ядуучуудыг хөгжин цэцэглэж буй эдийн засагтай холбож өгөх ёстой. Хөдөө аж ахуйн худалдаа гэх мэт бусад худалдаа арилжааг эрчимжүүлэх тусалцаа нь мөн чухал. Эдийн засгийн гэнэтийн өөрчлөлтөд тохирсон, шинэ маягийн, үнэтэй биш, нийгмийн хамгаалалын тогтолцоонууд шаардлагатай. Ажил хийхээр шилжин суурьшилт хийх нь ажилчдад ашигтай байж болох боловч нийгмийн хамгаалалын тогтолцоо нь ажилчдын шилжин суурьших эрхийг сайтар баталгаажуулж, хүний наймаа болон хүчээр албадан ажиллуулах гэх мэт үзэгдлээс сэрэмжилж чадахуйц байх ёстой. Ямарваа өвчин тахал, байгалийн гамшиг, байгаль орчин онцгой доройтох зэргийг авч хэлэлцэхэд бүсийн хамтын үйл ажиллагаа маш чухал юм.

Хамтын үйл ажиллагааны хэлбэр

Азийн орнуудын хамтын ажиллагаа нь эдийн засгийн асуудлуудыг “Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо” -нд төвлөрсөн төрөл бүрийн чуулга уулзалтуудаар хэлэлцдэг. Эдгээр чуулга уулзалтуудаас бүсийн эдрээтэй болон ялгаатай байдалд нийцсэн төрөл бүрийн хурдтай арга замыг санал болгодог. “Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо +3” нь үүний зохицуулагч үүрэг гүйцэтгэгч болон гарч ирж байгаа ба, мөн “Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Нарийн Бичгийн Дарга Нарын Газар” болоход тохиромжтой газар болж байна. Эцсийн дүндээ Азид нэг зах зээл ноёлж нийтийг хамарсан хууль дүрэмтэй болж, нэг мөнгөн дэвсгэрт хэрэглэж мөн ажилчид улс хооронд чөлөөтэй зорчих эрх чөлөөг эдлэх боломжтой болно. Эдгээр бодлогуудад холыг харсан хэтийн зорилт шаардлагатай. Азийн нэгдэлийг хялбарчлахийн тулд, түүний нөлөөг яаж даван туулж болох, яаж хөгжлийг нэмэгдүүлж түүнийг тогтвортой болгох талаар хийсэн энэхүү судалгаанаас заримийг сонгож хэрэглэж магадгүй юм. Азийн бүсчлэл бүсийн болон бүх дэлхийн сайн сайхны төлөө хувь нэмэрээ оруулах боломжтой гэдэгт улам итгэлтэй болсоор байна.

Бид бүхэн хүчирхэг, хөгжингүй, улам гадагш тэмүүлсэн Азийн эдийн засгийн нэгдмэл байдлын дөнгөж эхлэлийн гэрч болж байна. Азийн бүсчлэл бий болж байгаа нь түүхэн чадварлаг хүч буюу энэ нь бүсийн болон дэлхийн хөгжил цэцэглэлтийг авчрах хамтын нөхөрлөл юм.

Азийн Бүсчлэлийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааг Нэгтгэх нь: Хэлэлцэх Асуудал

Сэдэв	Азийн эдийн засгийн нэгдэл: Цаашдийн замнал	
	Чухалчлан үзэх зүйлс	Явуулах Бодлого
Үйлдвэрлэлийг Нэгтгэх	<ul style="list-style-type: none"> • Бүсийн эдийн засгийн хөрөнгө оруулалт ба үр бүтээмжийг өсгөн нэмэгдүүлэх • Нэгдсэн үйлдвэрлэлтийн харьцангуй давуу талыг бэхжүүлэх • Техникийн шинэчлэл хийх болон эдийн засгийн мэдлэгээ дээшлүүлэхийг дэмжих 	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн худалдааны тогтолцоог дэмжих • Бүс нутгийн хамтын ажиллагааг улам гүн гүнзгийрүүлж үргэлжлүүлэх • Дэд бүсийн худалдааны гэрээнд хэрэглэх шилдэг зааварчилгаануудыг боловсронгуй болгох • Бүс дэх улс хоорондын холбогдох чадварыг сайжруулах
Санхүүгийн зах зээлийг нэгтгэх	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хямралыг даван гарах чадварыг нэмэгдүүлэх • Улам өргөн хүрээтэй гүн гүнзгий бүсийн санхүүгийн зах зээл бий болгох • Хөрөнгө оруулагчдын ашгийг нэмэгдүүлж бүсийн оролцоог бэхжүүлснээр компанийн хөрөнгөөс гарах зардалыг багасгах 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зах зээлд тавих хяналтыг чангатгаж -"Азийн Санхүүг Тэнцвэржүүлэх Харилцан Яриаг" бий болгох • Тогтсон стандарт болон хамтын зөвшилцөлийг дэмжих • Санхүүгийн зах дотор ялангуяа дотоодын мөнгөн дэвсгэртийн үнэт цаасны зах зээл, мөн түүний дэд бүтэцийг бэхжүүлэх • Хөрөнгийн дансыг болон хил давсан санхүүгийн үйл ажиллагааг чөлөөтэй явуулах
Макро эдийн засгийн уялдаа холбоог зохицуулах	<ul style="list-style-type: none"> • Макро эдийн засгийн болон валютын ханшны тогтвортой байдлыг сахих • Дэлхийн эдийн засгийн өөрчлөлтүүдийг зөөлрүүлэх. Үүнд бүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүсийн гаднах хадгаламжийн сан багтдаг • Хөрөнгө оруулалт ба өсөлтийг хөгжингүй орнуудад нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • "Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Нарийн Бичгийн Дарга Нарын Газар" байгуулснаар илүү сайн макро эдийн засгийн хяналт зөвлөлгөө өгөх • "Чианг Май Санаачлага"-ыг улам сайжруулах • Валютын ханш макро эдийн засгийн бодлого зохицуулалтийг хянах
Хөгжлийг ахиулж тогтвортой болгох	<ul style="list-style-type: none"> • Ядуурлыг багасгаж орлогын ялгааг багасгах • Хамгийн доод цалинг нэмэгдүүлж хөгшдийг тэтгэх • Тахалтай тэмцэж гамшгийн нөлөөг сулруулах • Хүрээлэн байгаа орчныг тойрсон асуудлуудыг авч хэлэлцэх 	<ul style="list-style-type: none"> • Ядуусийг хөгжиж буй бүсийн эдийн засагтай холбож өгөх • Тохирсон үнэтэй үр ашигтай нийгмийн хамгаалалтын тогтолцоог хөгжүүлэх • Ажилчдийн шилжин суурьших асуудлыг зохицуулах • Бүсийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах • Хөгжил дэвшлийг тогтвортой байлгах